

**БАТЛАВ.**

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

**Д.ЭНХТУЯА**

2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр

**АСРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хууль боловсруулах үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд иргэн өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, асруулах тохиолдолд нийгмийн хамгаалал, тусламж авах үндсэн эрхийг баталгаажуулсан. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа–2050”, Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ахмад настанд чиглэсэн урт хугацааны асаргаа, асрах үйлчилгээний хувилбарт хэлбэрийг хөгжүүлэх, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоог дэмжих зорилтыг тодорхой тусгасан.

Монгол Улсад хүн амын насжилт эрчимтэй явагдаж, ахмад настны эзлэх хувь 10 хувиас давж, 2050 он гэхэд таван хүн тутмын нэг нь ахмад настан болох төлөвтэй байна. Одоогоор ахмад настнуудын тодорхой хэсэг ганцаардал, ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн боломж хязгаарлагдмал байдал, нийгмийн оролцооны дутагдал, асрах үйлчилгээний хүртээмжгүй байдлаас үүдэлтэй эрсдэлд өртөж байна. Хүний эрхийн Үндэсний комисс болон бусад байгууллагуудын судалгаагаар ахмад настнуудын ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, үл хайхрах асуудал бодитой тулгамдсан хэвээр байгааг тодорхойлсон байдаг.

Асрах үйлчилгээ нь өнөөг хүртэл нийгмийн халамжийн салбарын хүрээнд тодорхой зохицуулалтгүй, институцийн бус, стандарт, мэргэжлийн зохицуулалт сул, сайн дурын хэлбэрээр гэж хэлж болохоор хэрэгжиж ирсэн. Үүний улмаас асарч үйлчлүүлэх иргэний эрх, аюулгүй байдал бүрэн хамгаалагдахгүй, асран хамгаалагчдын хөдөлмөрийн нөхцөл, хариуцлага тодорхой бус, төрөөс дэмжих, хамтрах, үйлчилгээ худалдан авах, санхүүжүүлэх тогтолцоо бүрдээгүй байна. Нөгөө талаар асрахуйн ажлын ихэнх ачаалал гэр бүл, ялангуяа эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөр дээр тогтож, жендерийн тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлж байна. Олон улсын байгууллагуудын тооцооллоор асрахуйн үйлчилгээний хүртээмжийг сайжруулснаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих бодит боломж бүрдэнэ.

Иймд асрах үйлчилгээг нийгмийн халамжийн хавсрага, туслах хэлбэрээс ангид, бие даасан, мэргэжлийн, хүний эрхэд суурилсан үйлчилгээ болгон хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлага үүсээд байна.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ**

Асрах үйлчилгээний тухай хуулийн зорилго нь асрах үйлчилгээний төрөл, хэлбэр, ангилал, стандарт, чанар, хүртээмж, санхүүжилт, хүний нөөц, үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ авч буй иргэний эрх, үүрэг, хариуцлагыг цогцоор нь зохицуулахад оршино.

Хуулийн үйлчлэл нь өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, архаг болон даамжирсан өвчтэй, тодорхой хугацаанд өдөр тутмын амьдралын дэмжлэг, нөхөн сэргээх асаргаа, хүний эрх ба нийгмийн оролцооны дэмжлэг шаардлагатай хүн болон тэдгээрт асрах үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулахад чиглэгдэнэ.

### **Гурав.Хуулийн төслийн үндсэн үзэл баримтлал**

Хуулийн төсөл нь дараах суурь үзэл баримтлалд тулгуурлана. Үүнд:

- **Хүний эрхэд суурилсан хандлага:** Асрах үйлчилгээ авч буй иргэнийг халамжийн объект бус, эрх бүхий хэрэглэгч гэж үзэж, нэр төр, хувийн нууц, аюулгүй байдал, сонголт хийх эрхийг баталгаажуулна.
- **Хувилбарт асрах үйлчилгээний тогтолцоо:** Асрах үйлчилгээг гэрээр, өдрөөр, цагаар, түр хугацаагаар, байнга байршуулах болон хөдөлгөөнт хэлбэрээр уян хатан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- **Эрсдэлд суурилсан зохицуулалт:** Асрах үйлчилгээний төрөл, хэлбэр, хугацаа, эрчим нь асарч үйлчлүүлэх иргэний бие махбод, сэтгэл зүй, эрх, санхүүгийн эрсдэлийн үнэлгээнд үндэслэнэ.
- **Мэргэжлийн хүний нөөц, стандарт:** Асрах үйлчилгээ нь тусгай сургалтанд хамрагдсан, гэрчилгээтэй асаргааны мэргэжилтэн, мэргэжлийн багийн оролцоотой, стандарт, ёс зүй, хяналтын тогтолцоотой байна.
- **Төр–хувийн хэвшил–төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа:** Төр нь бодлого, стандарт, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж, үйлчилгээний гүйцэтгэлийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх боломжийг дэмжинэ.
- **Санхүүжилтийн тогтвортой тогтолцоо:** Асрах үйлчилгээний санхүүжилтийг нийгмийн халамжийн тэтгэмжтэй адилтгахгүй, үйлчилгээний бодит өртөг, чанарт суурилсан байдлаар хувийн хэвшлийн оролцоог аль болох дэмжиж, төрөөс худалдан авах, дэмжих механизмыг бий болгоно.

### **Дөрөв.Хэрэгжилт, үр нөлөө**

Хуулийг хэрэгжүүлэхдээ хоёр жилийн шилжилтийн хугацааг тогтоож, одоо үйл ажиллагаа явуулж буй асрах үйлчилгээ үзүүлэгчдийг стандарт, хүний нөөц, зөвшөөрлийн шаардлагад үе шаттай нийцүүлнэ.

Хууль батлагдсанаар:

- асрах үйлчилгээний хүртээмж, чанар сайжрах;
- ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралын чанар дээшлэх;
- гэр бүлийн асаргааны хэт ачаалал буурах;
- эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн оролцоо нэмэгдэх;
- асрах үйлчилгээний салбар ил тод, тогтвортой, мэргэжлийн тогтолцоотой болох нийгэм, эдийн засгийн эерэг үр нөлөө бий болно.

### **Тав.Хууль тогтоомжийн уялдаа**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад холбогдох хууль тогтоомжтой нийцэх бөгөөд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Нийгмийн халамжийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүснэ.

--oOo--